



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01

Биндэр сум

**Цэргийн шинэчилсэн бүртгэл явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн А/690 дүгээр захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг явуулах комиссыг доор дурдсан бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Г.Өнөболд (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Золбоо (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүдэд: Н.Болормаа (1-р багийн Засаг дарга)

Э.Мөнгөншагай (2-р багийн Засаг дарга)

Ж.Ганзоригт (3-р багийн Засаг дарга)

Х.Амарзаяа (4-р багийн Засаг дарга)

Б.Тунгалаг (5-р багийн Засаг дарга)

2. 2026 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ний өдрөөс 23-ний өдрийг дуустал сумын хэмжээнд зохион байгуулж явуулсугай.

3. Цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, 2025 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, цэргийн бүртгэлийн материал, мэдээ, судалгааг хугацаанд нь үнэн зөв гаргаж ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

